

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, нийт 15 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

9 дүгээр сарын 21-ний өдөр төрийн албан хаагчдын сургалт, урлаг, спортын “Нэг сэтгэл-Нэг баг” арга хэмжээг зохион байгуулж, 240 төрийн албан хаагч хамрагдсан. Төрийн байгууллагуудын албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой тус арга хэмжээнд үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор уламжлалт арга барилыг харуулсан тэмцээн уралдаан зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр Монголын лектор төвийн лектор Н.Төрболд “Өөрийгөө бүтээх харилцаа” сэдвээр лекцийг уншиж танилцуулсан.

Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр төрийн албаны шинэтгэл, төрийн албаны тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайханаар ахлуулсан ажлын хэсэг 9 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд манай аймагт ажиллаж төрийн албан хаагчдад төрийн албаны шинэчлэлийн бодлогын үзэл баримтлал, шинэ хуулийн үзэл санаа, ач холбогдол, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтын тухай, холбогдох журмууд, ёс зүй, анхаарах асуудлуудын талаар сургалт зохион байгуулсан.

Мөн нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 10 ахмад настантай уулзаж, тэдний санал хүсэлт, сургамж зөвлөгөөг сонсож, төрийн албаны шинэтгэлийн талаар яриа өрнүүлсэн юм.

Сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын харъяа хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-ын дарга, эрх зүйн ажилтнууд, Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, Шүүхийн шинжилгээний алба, Онцгой байдлын газар, аймгийн сургууль, цэцэрлэгийн удирдлагууд зэрэг нийт 37 байгууллагын 346 төрийн албан хаагч хамрагдсан.

Иргэдэд мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгор орон нутгийн Говьсүмбэр телевизээр 8 төрлийн мэдээллийг өдрийн 3 удаагийн давталттайгаар, Монголын үндэсний олон нийтийн телевизээр 6 мэдээг дамжуулаад байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2019 оны 09 дүгээр сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 3 907 978, 4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 5 180 000,00 төгрөг төвлөрүүлж 132.5 хувьтай байна.

2019 оны 9 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар татвар төлөгчөөр бүртгэлтэй ХК 1, ХХК 296, ББН 5, ЗБН 10, Хоршоо 27, ОНӨҮГ 6, Салбар 68, Хадгаламж зээлийн хоршоо 1, Төсөвт байгууллага 57, Төрийн бус байгууллага 89, Шашны байгууллага 5, Сан 9, Олон нийтийн байгууллага 15, нийт хуулийн этгээд 589 байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 5117.7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 5617.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийн 661.0 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр:

2019 оны 08 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг бэлтгэж аймгийн болон хэлтсийн цахим хуудсанд байршуулж хэвлэмэл хуудсаар 51, цахимаар 136 хэрэглэгчид хүргүүлсэн.

Ажиллах хүчний судалгаанд Сүмбэр сумын 2 багийн 20 өрх, Шивээговь сумын 1 багийн 10 өрх хамрагдлаа.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:

Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 08 дугаар сарын сарын шилэн дансны мэдээллийг шалгахад 19 байгууллага хангалтгүй, 63 байгууллага хангалттай үнэлэгдсэн. Хуулийн хэрэгжилт 2019 оны 8 дугаар сарын байдлаар 76.4 хувь байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон:Тэтгэвэр

№	Төрөл	2018.09.24		2019.09.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/	
1	Өндөр настан	1608	4652014,0	1716	5133549,8	106
2	Хөгжлийн бэрхшээлтэй	306	636450,2	328	743073,7	22
3	Тэжээгчээ алдсан	122	273405,9	123	271741,4	1
4	Үйлдвэрийн осол	52	192142,2	50	232652,7	2
	Нийт дүн	2088	5754012,3	2217	6381017,8	129

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2018.09.24		2019.09.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	1203	118357,7	791	103445,1
2	ЖБА тэтгэмж	302	386417,6	254	398942,1
3	Оршуулга	57	57000,0	48	48000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	37	40212,7	6	2494,4
5	Ажилгүйдэл	149	175240,1	151	275243,9
	Нийт дүн	1748	777228,1	1250	828125,51

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2018.09.24	2019.09.24
Шинээр	118	209
Мөнгө тушаасан	531	617
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	100549,3	191744,2

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:**

2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Хуулийн цаг нэвтрүүлгийг хуваарийн дагуу аймгийн Прокурорын газраас “Авлига, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр мэдээлэл бэлтгэн орон нутгийн Залуус телевизээр иргэдэд хүргэсэн.

Архивын ажлын чиглэлээр:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 11 хөмрөгийн 1984-1987 оны 3962 хадгаламжийн нэгжийн 896531 хуудас баримтыг цахимжууллаа. Архивын баримтаас 6 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлсэн байна.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан -40
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -46
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 32
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 8
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -23

- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -18

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 1
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 69
- Гэрээний бүртгэл - 54
- Барьцааны гэрээний бүртгэл - 249
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -4

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -8

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар -33
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-287-г олгож нийт 891 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн байна

Цагдаагийн хэлтэс нь:

Иргэд, хуулийн этгээдээс 381 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 140 буюу 36.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 241 буюу 63.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 40-өөр буюу 28,5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 5-аар буюу 2 хувиар, нийт хүлээн авсан гомдол мэдээлэл 35-аар буюу 8,4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хүнд гэмт хэрэг 9 бүртгэгдсэн нь 6 –аар буюу 40 хувиар буурч
- хөнгөн гэмт хэрэг 79 бүртгэгдсэн нь 18-аар буюу 18,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт

2019 оны эхний 8 сарын байдлаар хэрэг бүртгэлд /эзэн холбогдогч нь тогтоогдоогүй/ 98 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14-өөр буюу 12.5 хувиар буурч, үүнээс 41 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 9.1 хувь буурсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сургуулийн эргүүл”-ийг 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тогтмол ажиллуулах талаар албан мэдэгдлийг сургуулийн захиргаанд хүргүүлж биелэлтийг нь өдөр бүр шалган ажиллаж байгаа бөгөөд “Сургуулийн эргүүл” болон нийгмийн ажилтнуудтай биечлэн уулзаж хэрхэн үүрэг гүйцэтгэх талаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүлгэмийн гишүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын сэргийлэгч хүүхдүүд болон удирдагч багш нарт нь “Хүүхэд хамгааллын тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Зөрчлийн тухай” хуулиудаар сургалт зохион байгуулж, 2019-2020 оны хичээлийн жилд ажиллах төлөвлөгөө гаргасан. Тус сургалтанд 40 багш, сурагч хамрагдсан.

Уул, уурхайн жишиг сургууль Политехникийн коллежийн 1 дүгээр курсын оюутнууд болон дотуур байранд амьдардаг 150 оюутанд “Архи тамхины хор хөнөөл”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Хүүхэд хамгааллын тухай хууль” сэдвүүдээр, сургуулийн өмнөх боловсролын ахлах, бэлтгэл бүлгийн 460 хүүхэд, ерөнхий боловсролын 5 сургуулийн бага ангийн 1230 хүүхдэд “Замын хөдөлгөөнд хэрхэн аюулгүй, зөв оролцох вэ”, “Гар утсаар тоглохгүй байх” сэдвүүдээр 7 удаагийн сургалт, ерөнхий боловсролын

сургуулийн ахлах ангийн 780 хүүхэд, 360 эцэг, эхэд “Цахим донтолт”, “Архи тамхины хор хөнөөл” сэдвээр 6 удаагийн сургалт зохион байгуулсан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг баар, ресторан, зочид буудал болон Уул уурхай-Хайлуур жонш, Төмрийн хүдэр зэрэг худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд болон хүүхдийн хөдөлмөр эрхэлж болзошгүй газруудаар “Насанд хүрээгүй хүүхдийг ажилуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын хүрээнд “ Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Хүн худалдаалахтай тэмцэх тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай хууль” - д болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн актын хэрэгжилтийг шалган ажилласан. Шалгалтын үеэр зөрчил дутагдал илрээгүй.

Мөн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаал хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмын хэрэгжилтэнд хяналт тавьж зөвлөн туслах, байгууллага хоорондын хүүхэд хамгааллын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран сургууль, цэцэрлэг, Политехникийн коллежид хамтарсан шалгалтыг хийж цаашид хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөмж өгсөн.

Шүүхийн шинжилгээний алба нь:

Хэргийн газрын үзлэгт 12 удаа оролцсоноос хулгайн гэмт хэргийн 1, зам тээврийн ослын 7, бусад хэргийн газрын үзлэгт 3 удаа оролцсон. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 307 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Тайлант хугацаанд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 18 удаа хийж дүгнэлт гаргасан. Мөн 1 цогцосны задлан шинжилгээнд оролцсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь:

Суллагдах хугацаа дөхсөн 30 хоригдолд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн холбогдох заалтаас сургалт зохион байгуулсан.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран 2 хоригдлыг бичиг баримтжуулсан ба 8 хоригдлын бичиг баримтыг захиалан Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

9 дүгээр сард шүүхээс шинээр 51 гүйцэтгэх хуудасны 904.299.100 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч цахим бүртгэлд бүртгэсэн.

2019 оны 09 дүгээр сард төлбөрийн 11 гүйцэтгэх баримт бичгийн 12.446.100 төгрөгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 29.7 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь:

Улсын байцаагчид болон ААНБ, иргэний ирүүлсэн хүсэлтийн дагуу усны 37, хоолны 9, хүнсний ногооны 38, сүү сүүн бүтээгдэхүүний 7, будаанд 11, гурил гурилан бүтээгдэхүүнд 15, жимсний 3, чихэр 4, будаа 7, арчдасны 52, нийт 183 сорьцонд 2- 9 үзүүлэлтээр хими, нян судлал, хорио цээрийн шинжилгээг гүйцэтгэсэн бөгөөд эерэг сорьц 7 илэрсэн.

Аймгийн хэмжээнд төмс хүнсний ногоо тариалагч 8 аж ахуй нэгж, иргэд, хоршоодын байнгын усалгаатай талбай болон хүлэмжинд тариалсан хүнсний ногоонд Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран талбайн үзлэг хийж 12 төрлийн 41 дээжинд хорио цээр болон химийн шинжилгээг /мэдрэхүй, нитрат, хөнөөлт шавьж/ үзүүлэлтээр гүйцэтгэсэн. Эерэг сорьц илрээгүй.

“Шинэ хөдөө” төслийн санхүүжилтээр Элайза аппарат, Vortex (Хуруу шил сэгсрэгч), найман сувагт автомат пипетка, афлотоксин М1, авермиктений үлдэгдэл, хлорофеникол, стрептомицинийн оношлуур, тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан.

“ШИВЭЭ ОВОО” ХК-ны ажилтнуудын хоолыг нийлүүлдэг Тод Ган ХХКомпаны хоолны газрын ажилтнуудад 1.10.1, 1.10.2 кодтой хяналтын хуудсыг танилцуулахын зэрэгцээ эрүүл ахуйн зохистой дадлыг хэрхэн төлөвшүүлэх, хоолны хордлого хордлогот халдвар, түүнээс хэрхэн сэргийлэх, хоол хүнсийг хэрхэн аюулгүй бэлтгэх, хадгалах, гарыг зөв угаах, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн зарчим зэрэг сэдвүүдээр хүнсний чанарын болон эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нар сургалт зохион байгууллаа. Сургалтанд 12 ажилтан оролцсон.

Онцгой байдлын газар нь:

2019 оны 09 дүгээр сарын 09-21-ний өдрүүдэд Дорноговь аймагт зохион байгуулагдсан Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Элчин сайдын яам, Энэтхэг-Номхон далайн цэргийн командлалтай хамтран “Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль, туршлага солилцох үйл ажиллагаанд аймгийн удирдлага, Онцгой байдлын газрын алба хаагчид амжилттай оролцоо. Тус арга хэмжээнд 15 албан хаагч оролцсон.

Онцгой байдлын газар сүүлийн үеийн дэвшилтэд технологи бүхий “Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвтэй болж, 2019 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр нээлтээ хийлээ. Энэхүү төв нь шинээр байгуулагдсанаар аймагт болон бусад аймагт гамшиг осол болох үед ард иргэд болон холбогдох газруудад мэдээллийг түргэн шуурхай дамжуулах ач холбогдолтой юм.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Боловсролын байгууллагуудад Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн бүх нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан гамшгаас хамгаалах, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг хангах шалгалтыг 2019 оны 08 дугаар сарын 26-31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 21 аж ахуй нэгж байгууллагад гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, давхардсан тоогоор гал түймэр гарч болзошгүй 254 зөрчил илрүүлж, газар дээр нь 35 зөрчлийг арилгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 8, танилцуулга 1-ийг тус тус бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, эрх бүхий албан тушаалтнуудад байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажиллаж байх талаар мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмжийг өгч ажилласан.

Гал түймэр унтраах, аврах 37 дугаар анги, Эрэн хайх, аврах бүлгийн бие бүрэлдэхүүн Сүмбэр, Шивээговь сумын гэр хороолол, айл өрхүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулсан. Үзлэгээр 115 өрх хамрагдаж, нийт 15 зөрчил илрүүлж, 8 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 7 зөрчлийг эргэн шалгах хугацаатай үүрэг чиглэл өгч, 286 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг хүргэж сэрэмжлүүлэг, гарын авлага материалыг тарааж ажилласан. Аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээр 2 байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гарган 25000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Гал унтраах тархалтын сургуулийг “Хаан банк”, “Төрийн банк”, “Хас банк, гал унтраах тактикийн сургуулийг “Улсын нөөцийн салбар”-т гарсан гал түймрийг унтраах сургалтыг зохион байгуулсан. Сургуульд давхардсан тоогоор гал түймэр унтраах ангийн 18 алба хаагч, аж ахуй нэгж байгууллагын 28 ажилтан хамрагдан тактик, техникийн алдаа дутагдалгүй ажилласан.

2019 оны 09 дүгээр сард аймгийн хэмжээнд гал түймрийн дуудлагаар 3 удаа ажиллаж ард иргэдийн 20 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалж, 3600.0 мян.төгрөгийн эд хөрөнгө гал түймэрт өртөж шатсан байна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ,СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Соёл, урлагийн чиглэлээр:

2019-2020 оны хичээлийн шинэ жилийг тохиолдуулан багш нарын бага хурлыг зохион байгууллаа. Бага хурлаар 2018-2019 оны хичээлийн жилийн зорилтын хэрэгжилт, ЭЕШ-ын мэдээ тайлан, цэцэрлэг сургуулийн хоол үйлдвэрлэл, эрүүл ахуй аюулгүй байдлын талаарх мэдээлэл, сургуулийн орчин дахь цогц аюулгүй байдал, багшийн ёс зүйн асуудал, цахим орчин дахь багшийн ёс зүй, 2019-2020 оны хичээлийн жилийн зорилт зэргийг дэвшүүлэн хэлэлцсэн. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд ЭЕШ –ын дундаж оноо улсын дунджаас давсан, сурагчид нь улсын уралдаан тэмцээнд амжилт гаргасан 21 багш, Шивээговь сумын 3 дугаар сургууль, Сүмбэр сумын 2 дугаар сургуулийг урамшуулсан. Бага хуралд аймгийн бүх сургууль, цэцэрлэг, коллежийн 330 багш, удирдах ажилтан оролцсон.

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ОНХСан болон “Эх соёл- Их үндэс” хөтөлбөрийн хүрээнд аймгийн сургууль, цэцэрлэгүүдэд компьютер, тоног төхөөрөмж, байгалийн ухааны кабинет, Монгол, Англи хэлний кабинет, Монгол зан заншлын өргөөгөөр хөрөнгө оруулалтын ажлууд хийсэн.

Багш нарын баярыг угтан цэцэрлэгийн багш нарын дунд “Спортын бага наадам”-ыг 2019 оны 09-р сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг тэмцээнд найман цэцэрлэгийн 100 гаруй багш, ажилчин хурд хүч авхаалж самбаагаа сорин уралдлаа .

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран 1, 2, 5 дугаар сургуулиудын 10-12 дугаар ангийн нийт 400 сурагчид “Ажил мэргэжлээ зөв сонгох нь”, “Давуу талдаа суурилан мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?”, мэргэжил сонголтын алхмуудыг хэрэгжүүлэх нь” сэдэвт бүлгийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар сурагчдад өөрийгөө танин мэдэх, сурч хөгжих чадварт суралцах, мэргэжил сонгоход гаргадаг нийтлэг алдаанууд, мэргэжил сонголтын 6 алхмын талаар ойлголт, мэдлэгтэй болсон. .

Соёл урлагийн чиглэлээр:

2019 оны 09 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд “Соёл урлагийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан спортын 7 төрлийн уралдаан тэмцээн зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Боловсрол, соёл, урлагийн газар, Боржигин чуулга, Нийтийн номын сан, Боржигин өв музей, Баянтал сумын соёлын төв, Шивээговь сумын соёлын төвийн хамт олон, нийт 100 гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Онцгой байдлын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Дэлхийн зөн ОУБ Бор-Өндөр-1 ОНХ нартай хамтран, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангах, тэсвэр хатуужилтай, хүнлэг энэрэнгүй иргэн болгон төлөвшүүлэх, аюулгүй амьдрах арга ухааны мэдлэг эзэмшүүлэх, гамшигт нэрвэгдэгсдийг аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургаж дадлагажуулах, зорилгоор “Өсвөрийн аврагч-2019” тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 2019 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Тус сургалтанд 35 сурагч хамрагдлаа.

“Залуусын хүч” залуучуудын хөгжлийн сарын аяныг 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж байна. Аяны хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. “Залуусын дуу хоолой” цахим дууны тэмцээн, “БИ ХАЛАМЖТАЙ ААВ” сургалт, “Талархал” захидлын уралдаан, “Миний гэр бүл-Миний аз жаргал” өдөрлөг, “Үлгэрч

аав, ээж” аян, “Хүүхдийнх нь төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгодог байх” уриалга, “Эрүүл бие-Саруул ухаан” ажлын байрны дасгал хөдөлгөөний чөлөө зэрэг ажлуудыг зохион байгуулаад байна.

Гэрээр айлчлагч хөтөлбөрийн хүрээнд хөгжих өрхийн 20 өрхөөр айлчилж, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг тандан үнэлгээ хийж, судалгаа авч байна. Өрхүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийснээр тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа өрхүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Эрүүл мэндийн газар, Өлзийтсүмбэр фарм эмийн сантай хамтран 1 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн 26 сурагчид "Антибиотикийн зохистой хэрэглээ" дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод буй нянгийн тэсвэржилттэй тэмцэхийн тулд антибиотикийг хэрхэн зөв зохистой хэрэглэх талаар сургалт зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/303 тоот захирамжаар “Цус эрүүл бол -Бие эрүүл-3” сарын аяныг зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирусын халдвар илрүүлэг шинжилгээг зорилтот 15-54 насны хүн амын дунд зохион байгуулж одоогийн байдлаар шинжилгээнд хамрагдалт 47 хувьтай байна.

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн чиглэлээр:

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 15 иргэнээс, 20 шинэ ажлын байр бий болгоход 75000,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдлийг хүлээн авч, төсөл ирүүлсэн иргэдэд аж ахуй эрхлэх сургалтыг зохион байгуулж санхүүгийн анхан шатны мэдлэгтэй болгосон.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 7 байгууллагын 20 ахмад мэргэжилтнээс түр ажлын байраар хангах төслийг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн 10 дугаар сарын 01-ний өдрөөс гэрээ байгуулахаар ажиллаж байна.

2019 оны 9 дүгээр сарын 19-ний байдлаар нийт 5984 иргэнд 1.507.679.388 төгрөгийг зарцуулсан байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны 24 иргэнд “Хүнсний эрхийн бичгийн журам”-ын талаарх сургалтыг зохион байгуулан 3 иргэнийг ажлын байранд зуучилсан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр:

2019-2020 оны мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд өнгөрсөн жил бэлтгэсэн 80тн өвс, 26 тн тэжээл, Сүмбэр суманд 80.3 тн өнжмөл өвс, Баянтал суманд 20 тн өнжмөл өвс, 3.5 тн тэжээл, Шивээговь суманд 14 тн өнжмөл өвс буюу сумдын аюулгүйн нөөцөд нийт 114.3 тн өвс, 3.5 тн тэжээлийн нөөцтэй байна.

Малх отрын бүсэд 9 дүгээр сарын байдлаар 118 өрхийн 71994 мал өвөлжихөөр буусан байна. Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны Аймаг дундын отрын захиргааны мэргэжилтэн Малах отрын бүсийн бэлчээрийн ургац, даацыг тодорхойлох ажлыг гүйцэтгэн, ургац 1.0 ц/га, даац нь хонин толгойд шилжүүлснээр 78.9 мян мал багтах тооцоо гаргасан.

Дорнод, Төв, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгийн нутагт Сүмбэр сумын 16 малчин өрхийн 14030 толгой мал өвөлжихөөр отроор нүүсэн.

2019 онд бэлтгэсэн хонь, тэмээний ноосны урамшууллын материалыг сумдаас авч, баримтыг тулган, шалгав. Аймгийн нэгтгэсэн дүнгээр нийт 214 малчин өрх 78.3 тн хонь, тэмээний ноосыг үндэсний үйлдвэрт тушаасан байна.

Аймгийн бизнес эрхлэгчид, малчдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, өргөжүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, сурталчилах, тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэх, бизнесийн харилцаа тогтоох, зах зээлийн холбоо тогтоох, Монгол мал, Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах Шилмэл мал шилдэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдааг 2019 оны 09 дүгээр сарын 06-12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 32 иргэн, 1 хоршоо өөрсдийн үйлдвэрлэсэн 67 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр оролцож 25.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний 08 дугаар сарын үнийн мэдээ

Наймдугаар сарын сүүлч 9-р сарын эхээр малчдаас зах зээлд нийлүүлэгдэж буй махны нийлүүлэлт өсч байгаа тул зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай, цул/ махны үнэ 500 төгрөгөөр, адууны ястай мах 500 төгрөгөөр, төмс болон зарим, хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 100-300 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Гэвч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000-1200 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ /төг/	Доод үнэ /төг/	Өссөн бүүрсан үзүүлэлт/+-/	
1	Үхрийн мах	Ястай	9500	8000	500
		Цул	12000	11000	-500
2	Хонины мах	Ястай	7500	6500	-
		Цул	11000	10000	-
3	Адууны мах	Ястай	8000	5000	-500
		Цул	9500	9000	-
4	Ямааны мах	Ястай	7000	6000	-
		Цул	9000	8500	-
5	Тахианы мах	Гуя	8500	8500	+250
		Мөч	9200	8500	
6	Лууван	Монгол	2000	1500	+300
		Хятад			
7	Төмс	Монгол	1000	700	-50
		Хятад			
8	Байцаа	Монгол	1500	1200	-300
		Хятад			-
9	Чинжүү	Монгол			-
		Хятад	7000	6800	
10	Манжин	Монгол	1300	1200	-50
		Хятад			-
11	Сонгино /бөөрөнхий/	Монгол	2000	1600	-
		Хятад	1600	1200	-
12	Улаан лооль	Монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	Монгол	3500	3000	-
14	Элсэн чихэр		2100	1800	-
15	Будаа	Цагаан будаа задгай 1кг /хятад/	2500	2000	-100
		Шар слава 1кг	3100	2900	-

		Гурвалжин слава 1 кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	1500	1400	-
		Сүү ХК 0.5л 3.2% тослогтой			
		Сүү ХК 1л 3.2% тослогтой	3000	2950	+300
17	Тараг	Задгай	2500	2000	
		Сүү ХК 1л 3.2% цэцгийтэй	4800	3800	-
18	Талх	Чойр /Шивээ/	1200	800	-
19	Өндөг	ОХУ	450	300	-5
		Монгол	400	250	-15
20	Алтан тариан гурил	Задгай дээд	1480	1400	-
		Задгай 1-р зэрэг	1100	1080	+
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савлагдсан д/дээд	1650	1600	-
		Савлагдсан дээд	1650	1600	-
		Савлагдсан 1-р зэрэг	1300	1200	-
		Савлагдсан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлынтос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1600	1500	-
		А/т савхан	1000	900	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр:

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Уст цэгийн цэвэрлэгээ”-г 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан “Хоггүй Цэвэрхэн Монгол” аяны хүрээнд Умард Говийн гүвээт, Халхын дундад талын сав газрын захиргаатай хамтран 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгууллаа. Тус цэвэрлэгээг Уулзварын гол, Цагаан дарь эх, Цоорхой рашаан гэсэн маршрутаар нийт 7 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 9 дүгээр сард 8 хугацааны мэдээг нийт 240, хөдөө, аж ахуйн ажиглалтын хашаалсан талбайд 10, хашаалаагүй талбайд 3, хөрсний чийгийн ажиглалтыг 3, климат агро дундаж хөдөө аж ахуйн тойм мэдээ болон 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус төв станцад дамжуулсан.

09 дүгээр сарын цаг уурын тойм мэдээгээр: 07,12-ны өдрүүдэд бороо орсон. Нийт 6.2 мм тунадастай. Салхи ихэнхи хугацаанд 6-11 м/сек хүрч салхилав. Агаарын дундаж температур 15.3 градус дулаан, хамгийн хүйтэн нь 13-ны шөнө 1.2 градус дулаан, хамгийн дулаан нь 12-ны өдөр 30.2 градус дулаан байсан.

9 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар хөдөө аж ахуйн цаг уурын тойм мэдээ: Бэлчээрийн нийт ургамлын ургалт сайн, бэлчээрийн ургамлын ажиглалтын төлөөлөх

ургамал болох хялгана, хөмүүлд хашаалсан ба хашаалаагүй талбайд хаталт, хагдралтын үе шат явагдаж байна. Ургамлын дундаж өндөр 9 см байна. Бэлчээрийн ургамлын хөнөөлт хортон мэрэгчдийн ажиглалтаар авгалдай, бие гүйцсэн царцаа ажиглагдаагүй. Мал аж ахуйд зохиогдож байгаа ажил, малын бэлчээрлэлтэнд цаг агаарын байдал хэвийн ажил саатаагүй. Бог, бод малын тарга хүч сайн, худгийн усаар ундаалж байна.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) нийт 46 сорьцыг авч, 9 дүгээр сарын 1-ээс 9 дүгээр сарын 19-ний өдрүүдийн дээжинд шинжилгээ хийсэн ба шинжилгээний дүнгээр дундажлахад азотын давхар исэл (NO₂) 0.010, сарын хүлцэх агууламж нь 0.050, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.008, сарын хүлцэх агууламж 0.050 байгаагаас харахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй.

Тээвэр, авто замын чиглэлээр:

09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 244 тээврийн хэрэгсэл хамрагдаж, өссөн дүнгээр 2529 тээврийн хэрэгсэл хамрагдаад байна.

Хот хооронд 453 иргэн, сум хооронд 142 иргэн зорчиж, 1080 авто тээврийн машинд ачаа тээврийн дагалдах хуудас, 17 таксинд замын хуудас олгон, 70 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

2019 онд газрын төлбөрийн орлогот 163.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 118.8 сая төгрөг төвлөрүүлж 72.5 хувийн биелэлттэй байна.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэх “Нийгмийн дэд бүтэц”-ийн чиглэлээр маягтын дагуу 20 барилга байгууламж бүртгээд байна.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 14 бүтээн байгуулалтын ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Захиалагчийн хяналтаар гарсан зөрчил дутагдлыг талбайн журнал болон амаар үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн Улсын төсөв, аймгийн “Орон нутгийн хөрөнгө оруулалт”, “Орон нутгийн хөгжлийн сан”, “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”, “Авто замын сан”-гийн хөрөнгөөр хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан, Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл авч, “Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем” болох www.tender.gov.mn сайтад байршуулж ил тод нийтлээд байна.

2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 68 төсөл арга, хэмжээний үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахаас 65 үнэлгээний хорооны захирамжийг гаргуулан биелэлтийг ханган ажиллаж байна. Тендер шалгаруулалтыг зохион байгуулсан 62, зарлагдаагүй 2, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт боловсруулагдаж байгаа 4 ажил байна. Гүйцэтгэл 93.8 хувьтай байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум:

Сумын Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 26-ны А/53 тоот захирамжаар сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах комисс томилогдон төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай газар дээр нь очиж танилцаж, үүрэг даалгавар өгч ажилласан.

“Шинэ хөдөө” төслийн хүрээнд сумын 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт тоног төхөөрөмж болон явуулын үйлчилгээнд тохирох чингэлэгийг аймгийн Засаг дарга гардуулж өглөө.

Сумын ЕБС-ийн 1-5 дугаар ангийн зорилтот бүлгийн 5 хүүхдэд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хичээлийн дүрэмт хувцас бэлэглэсэн байна.

Сумын Соёлын төвөөс Халх голын ялалтын 80 жилийн ойд зориулан “Халх гол 80” үзэсгэлэнг 09 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулж сумын иргэд, хүүхэд багачуудад үзэж сонирхуулсан.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалтын шинжилгээнд 360 толгой мал хамруулахаас 2019 оны 09 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд 4 суурийн 163 хээлтүүлэгч, 4 өрхийн 131 саалийн малнаас шинжилгээ авч гүйцэтгэл 81.6 хувьтай байна.

Сумын хэмжээнд одоогийн байдлаар нийт 1.9 га талбайд төмс, огурци, помидор, сонгино, чинжүү, манжин, лууван, хулуу гэх мэт хүнсний ногоо тариалснаас огурцы 0.14, чинжүү 0.1, хулуу 0.05, манжин 0.05, төм 0.15 тонныг хураан авсан.

Шивээговь сум:

“Нийтийн эзэмшлийн гудамж талбайн урсгал засвар”-ын ажлыг “Сүмбэр старлет” ХХК-тай 14.9 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авсан.

Мөн 3 дугаар цэцэрлэгийн сантехникийн засварын ажлыг “ОСО констракшн” ХХК-тай 7.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, 09 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авсан.

“Сумын төв талбайг тохижуулах ажил”-ын гүйцэтгэгчээр “Оч хийц” ХХК шалгарч, 49.6 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулаад байна.

“Суманд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсөв боловсруулах ажил”-ын гүйцэтгэгчээр “Гидродизайн инноваци” ХХК-ийг шалгаруулж, 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр гэрээг байгуулсан.

“Суманд хатуу хучилттай засмал зам тавих зураг төсөв боловсруулах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 дахь удаагаа зарлаж, хураангуй жагсаалтад бүртгэгдсэн 3 оролцогчид Зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагууд, мөн аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Политехникийн коллежтой хамтран “Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг”-ийг 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, 5 байгууллагын 18 албан хаагч оролцож, давхардсан тоогоор 213 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлж, 350 брошур, гарын авлага тараасан байна.

Шивээговь сумын түүх соёлын холбогдолтой үл хөдлөх дурсгалыг Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөгдөж буй солбицол тусгалын хэмжилтээр Зуун умай, Эрээний туурь, Хаялагын хиргисүүр зэрэг газруудад хэмжилт хийн “Зуун умай” хөшөөний хашаа хамгаалалтын өнгө үзэмжийг сэргээлээ.

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл хөтөлбөрт хамрагдах мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 30 иргэнийг хамруулсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд олон улсын Ахмадын баярыг тохиолдуулан “Ахмадаа хүндэлье” аяныг зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд “Ахмадын спорт-2019” тэмцээнийг 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, спортын 4 төрлөөр шилдгүүдээ шалгаруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан ажилгүйдлийг бууруулах, хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрт хамрагдахаар төсөл өгсөн 4 малчин өрхийн төсөл дэмжигдэж нийт 20 сая төгрөгийн малыг 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хүлээлгэж өгсөн.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттайгаар хүлэмжинд нарийн ногоо тариалах арга хэмжээнд зорилтот бүлгийн 5 иргэнийг хамруулан тариалалтыг хийж 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 320 кг өргөст хэмх хурааж аваад байна.

Сумын Мал эмнэлгийн нэгж бруцеллёз, цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 7417 малд хийж, мөн хөдөөгийн өрхүүдээр адууны нийлүүлгийн, ям, хачигийн халдвар, бог малын хээлтүүлэгч, саалийн малаас бруцеллёзын шинжилгээ авах ажлын зураглал гаргаж, цусны шинжилгээний дээжийг цуглуулсан.

Сүмбэр сум:

2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр “Үер усны ослоос урьдчилан сэргийлэх” самбарыг 6 дугаар багийн нутаг Чойроос 100км-ийн зайд Хөмүүлтийн гүүрэнд, аймгийн “Онцгой байдлын газар 50км” гэсэн самбарыг Чойроос 50км-н зайд Эрээн цавын ард байршуулсан.

2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний гаар, Дэлхийн Зөн ОУБ Бор-Өндөр 1 ОНХөтөлбөртэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрүүл амьдрал” явган аялалыг зохион байгууллаа. Тус аялалд Сүмбэр сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, хөгжих 55 өрх, хамтдаа хөгжье аяны 100 өрхийн төлөөллөөс бүрдсэн 102 иргэн хамрагдсан ба аялалын үеэр хурд хүч, авхаалж самбаагаа сорьсон 4 төрлийн тэмцээнийг зохон байгуулсан.

Тайлант сард Хамтарсан багийн шуурхай хурлыг 2 удаа зохион байгуулж хүүхэд хамгааллын 108 утаснаас ирүүлсэн 3 кейс, иргэний мэдээллийн дагуу 2 кейс дээр нөхцөл байдлын үнэлгээг хийн, аюулгүй байдлын хамгаалалтыг авч ажилласан.

2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр аймгийн Биеийн тамир, спортын газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран хөдөөгийн малчин залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор хөдөөгийн 4,5,6 дугаар багийн залуучуудын дунд “Хөдөөгийн баясгалан өдөрлөг”-ийг зохион байгуулж 200 гаруй малчин залуучууд оролцлоо. Өдөрлөгөөр холимог волейбол, олс таталт, хөгжилтэй буухиа, уян хатан, хөдөөгийн хүчтэн, АХА асуулт хариулт зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан.

2019 оны 09 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд золбин нохой, муур устгалын ажлыг зохион байгуулж, 244 нохой устгаж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэн ажиллалаа.

Намрын ангилалт, ээмэгжүүлэлтэнд 1400 хонь, 850 ямаа, 172 үхэр, нийт 2422 мал хамрагдахаас 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар ангилалтанд 4 дүгээр багийн 6 өрхийн 809 хонь, 719 ямаа, 5 бух, нийт 1533 мал, ээмэгжүүлэлтэнд 172 ямаа, 138 хонь, 5 бух нийт 315 мал хамрагдаж ажлын явц 63.2 хувьтай байна. Сумын хэмжээнд 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар төмс 32.52тн, хүнсний ногоо 29.02 тн, нийт 61.54 тн ургац хураан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.94 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ужиг халдварт 8 нэр төрлийн өвчнөөс хамгаалах био тарилгад нийт 50.000 толгой мал, амьтан хамруулахаас давхардсан тоогоор 57.296 толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 90 хувьтай, гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Сүмбэр сумын 6 дугаар багийн 60.094 толгой бог малыг дархлаажуулж, гүйцэтгэл 100 хувьтай, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд нийт 57.068 толгой охин төл хамруулахаас 56.770 толгой охин төлийг хамруулж гүйцэтгэл 99.4 хувьтай, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалганд нийт 70.000 толгой мал хамруулахаас 73.569 толгой бог малыг хамруулж, гүйцэтгэл 100 хувьтай байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР